

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/153/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit02@gmail.com

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Албан шаардлага	17
4.3 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БСУГ	Боловсрол Соёл Урлагийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/134
танай _____-ны № _____-г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
19020436

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>147,817,440.46</u>	<u>163,164,801.74</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	147,817,440.46	163,164,801.74
351	Түүхий эд материал	32,741,948.05	34,360,308.54
35110	Тусгай зориулалттай материал	31,812,684.05	33,709,098.54
35130	Эм боох материал	929,264.00	651,210.00
354	Хангамжийн материал	115,075,492.41	128,804,493.20
35410	Бичиг хэргийн материал	311,100.00	1,584,100.00
35420	Аж ахуйн материал	679,200.00	1,249,400.00
35440	Түлш, шатах тослох материал	4,562,299.85	4,637,688.00
35450	Барилгын засварын материал	1,423,800.00	881,100.00
35460	Хүнсний материал	104,600.00	852,900.00
35470	Бусад хангамжийн материал	107,994,492.56	119,599,305.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,213,871,214.76</u>	<u>3,265,081,616.47</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>3,213,871,214.76</u>	<u>3,265,081,616.47</u>
392	Биет хөрөнгө	<u>3,111,023,214.76</u>	<u>3,162,233,616.47</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,106,994,237.73	3,319,037,446.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	(192,041,129.73)	(321,265,345.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,583,000.00	34,583,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(34,583,000.00)	(34,583,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	283,004,361.60	288,164,530.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(220,667,044.98)	(236,905,142.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	210,778,232.04	203,785,234.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(146,896,663.12)	(149,259,612.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	320,000.00	320,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(192,000.24)	(224,000.28)
39217	Ном	69,723,221.46	58,580,506.02
393	Биет бус хөрөнгө	<u>102,848,000.00</u>	<u>102,848,000.00</u>
39303	Бусад биет бус хөрөнгө	102,848,000.00	102,848,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,361,688,655.22</u>	<u>3,428,246,418.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,361,688,655.22</u>	<u>3,428,246,418.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>3,361,688,655.22</u>	<u>3,428,246,418.21</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	692,850,054.86	692,850,054.86
51101	Өмч: - төрийн	692,850,054.86	692,850,054.86
512	Хуримтлагдсан үр дүн	<u>1,713,896,835.92</u>	<u>2,733,046,295.35</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,713,896,835.92	1,713,896,835.92
51220	Тайлант үеийн үр дүн		64,207,694.99
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	954,941,764.44	954,941,764.44
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,361,688,655.22</u>	<u>3,428,246,418.21</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,496,211,051.68	2,251,695,379.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,190,566,851.68	1,903,412,119.60
120	Нийтлэг татварын бус орлого	1,412,364,751.68	224,083,619.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,412,364,751.68	224,083,619.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,412,364,751.68	224,083,619.60
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,778,202,100.00	1,679,328,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,778,202,100.00	1,679,328,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	305,644,200.00	348,283,260.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,528,100.00	91,158,160.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,116,100.00	257,125,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,223,179,625.12	2,185,061,991.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,223,179,625.12	2,185,061,991.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,969,576,845.59	2,044,080,087.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,384,967,726.16	1,370,854,374.53
210101	Үндсэн цалин	856,849,594.70	863,073,017.23
210102	Нэмэгдэл	369,693,004.46	379,076,139.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,358,500.00	35,322,000.00
210104	Урамшуулал	114,066,627.00	93,383,217.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,171,084.06	179,124,545.71
210201	Тэтгэврийн даатгал	119,060,538.32	125,222,467.56
210202	Тэтгэмжийн даатгал	14,013,364.82	13,570,204.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,134,250.64	10,832,583.64
210204	Ажилгүйдлийн даатгал	2,726,192.34	2,681,909.12
210205	Эрүүл мэндийн даатгал	27,236,737.94	26,817,380.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	214,670,790.40	269,609,967.23
210301	Гэрэл, цахилгаан	14,461,240.80	12,423,625.38
210302	Түлш, халаалт	198,889,549.60	254,986,341.85
210303	Цэвэр, бохир ус	1,320,000.00	2,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,724,168.00	20,420,932.23
210401	Бичиг хэрэг	495,850.00	842,480.00
210402	Тээвэр, шатахуун	628,050.00	749,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	793,150.00	492,750.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	17,740,864.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	82,500.00	325,618.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,679,618.00	269,870.00
2105	Нормативт зардал	36,080,540.00	33,815,654.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	266,555.00	1,178,054.00
210502	Хоол, хүнс	33,765,485.00	29,169,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,048,500.00	3,468,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,327,319.36	1,860,500.00

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	2,327,319.36	1,860,500.00
2107	Томилолт, зочны зардал	335,000.00	292,000.00
210702	Дотоод албан томилолт	335,000.00	292,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,492,900.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,492,900.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,807,317.61	168,102,113.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,614,500.00	1,124,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,032,625.99	4,617,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,160,191.62	162,360,513.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,602,779.53	140,981,904.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	119,662,700.00	104,861,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,834,600.00	42,729,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,803,700.00	23,621,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,524,400.00	37,011,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	133,940,079.53	36,120,104.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	133,940,079.53	36,120,104.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,273,031,426.56	66,633,387.72
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,614,500.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,614,500.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	225,052.77	75,624.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	225,052.77	75,624.73
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	2,389,447.23	(75,624.73)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,275,420,873.79	66,557,762.99

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	692,850,054.86	954,941,764.44	438,475,962.13	2,086,267,781.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	692,850,054.86	954,941,764.44	438,475,962.13	2,086,267,781.43
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,275,420,873.79	1,275,420,873.79
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	692,850,054.86	954,941,764.44	1,713,896,835.92	3,361,688,655.22
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	692,850,054.86	954,941,764.44	1,713,896,835.92	3,361,688,655.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	692,850,054.86	954,941,764.44	1,713,896,835.92	3,361,688,655.22
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	66,557,762.99	66,557,762.99
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	692,850,054.86	954,941,764.44	1,780,454,598.91	3,428,246,418.21

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,083,846,300.00</u>	<u>2,027,611,760.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,778,202,100.00	1,679,328,500.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,778,202,100.00	1,679,328,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,778,202,100.00	1,679,328,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	305,644,200.00	348,283,260.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,528,100.00	91,158,160.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,528,100.00	91,158,160.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	223,116,100.00	257,125,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,116,100.00	257,125,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,082,345,500.00</u>	<u>2,018,238,410.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,082,345,500.00	2,018,238,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,828,742,720.47	1,877,256,505.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,384,967,726.16	1,370,785,782.09
210101	Үндсэн цалин	856,399,866.70	863,052,003.77
210102	Нэмэгдэл	419,030,542.46	379,076,139.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,866,500.00	39,822,000.00
210104	Урамшуулал	77,670,817.00	88,835,638.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,171,084.06	179,193,138.15
210201	Тэтгэврийн даатгал	119,060,538.32	125,291,060.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,013,364.82	13,570,204.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,134,250.64	10,832,583.64
210204	Ажилгүйдлийн даатгал	2,726,192.34	2,681,909.12
210205	Эрүүл мэндийн даатгал	27,236,737.94	26,817,380.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,757,090.25	269,685,355.38
210301	Гэрэл, цахилгаан	14,461,240.80	12,423,625.38
210302	Түлш, халаалт	201,975,849.45	255,061,730.00
210303	Цэвэр, бохир ус	1,320,000.00	2,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,977,930.00	6,031,690.00
210401	Бичиг хэрэг	518,050.00	1,464,440.00
210402	Тээвэр, шатахуун	627,850.00	749,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	793,150.00	492,750.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	329,880.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,664,000.00	2,965,150.00
2105	Нормативт зардал	32,577,090.00	36,517,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	159,955.00	600,000.00
210502	Хоол, хүнс	29,787,335.00	29,917,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,629,800.00	6,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилот, зочны зардал	335,000.00	292,000.00

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	335,000.00	292,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,492,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,492,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,464,800.00	13,750,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	262,100.00	2,199,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,202,700.00	11,550,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,602,779.53	140,981,904.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	119,662,700.00	104,861,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,834,600.00	42,729,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,803,700.00	23,621,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,524,400.00	37,011,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	133,940,079.53	36,120,104.38
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	133,940,079.53	36,120,104.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,500,800.00</u>	<u>9,373,350.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,499,900.00	9,373,350.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,499,900.00	9,373,350.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,499,900.00	9,373,350.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,499,900.00	9,373,350.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,499,900.00)</u>	<u>(9,373,350.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,936,453,600.00	1,936,453,600.00	-	100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,936,453,600.00	1,936,453,600.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,936,453,600.00	1,936,453,600.00	-	100.00

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,883,088,500.00	1,856,107,495.62	26,981,004.38	98.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,371,355,500.00	1,370,785,782.09	569,717.91	99.96
210101	Үндсэн цалин	869,017,000.00	863,052,003.77	5,964,996.23	99.31
210102	Нэмэгдэл	370,772,500.00	379,076,139.51	(8,303,639.51)	102.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,392,000.00	39,822,000.00	570,000.00	98.59
210104	Урамшуулал	91,174,000.00	88,835,638.81	2,338,361.19	97.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,132,900.00	179,193,138.15	5,939,761.85	96.79
210201	Тэтгэврийн даатгал	130,278,800.00	125,291,060.00	4,987,740.00	96.17
210202	Тэтгэмжийн даатгал	13,713,600.00	13,570,204.51	143,395.49	98.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,970,800.00	10,832,583.64	138,216.36	98.74
210204	Ажилгүйдлийн даатгал	2,742,700.00	2,681,909.12	60,790.88	97.78
210205	Эрүүл мэндийн даатгал	27,427,000.00	26,817,380.88	609,619.12	97.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	256,125,100.00	250,524,955.38	5,600,144.62	97.81
210301	Гэрэл, цахилгаан	19,075,100.00	12,423,625.38	6,651,474.62	65.13
210302	Түлш, халаалт	235,530,000.00	235,901,330.00	(371,330.00)	100.16
210303	Цэвэр, бохир ус	1,520,000.00	2,200,000.00	(680,000.00)	144.74
2104	Хангамж, бараа материалын зардал	5,985,000.00	5,690,080.00	294,920.00	95.07
210401	Бичиг хэрэг	700,000.00	699,480.00	520.00	99.93
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	749,350.00	650.00	99.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	492,750.00	257,250.00	65.70
210404	Ном, хэвлэл	485,000.00	483,350.00	1,650.00	99.66
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,965,150.00	34,850.00	98.84
2105	Нормативт зардал	50,940,000.00	36,517,900.00	14,422,100.00	71.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,000.00	600,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	44,340,000.00	29,917,900.00	14,422,100.00	67.47
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	446,000.00	292,000.00	154,000.00	65.47

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	446,000.00	292,000.00	154,000.00	65.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,104,000.00	12,103,640.00	360.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,200,000.00	2,199,900.00	100.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,904,000.00	9,903,740.00	260.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,365,100.00	80,346,104.38	(26,981,004.38)	150.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,365,100.00	44,229,000.00	9,136,100.00	82.88
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,865,100.00	42,729,000.00	9,136,100.00	82.38
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		36,117,104.38	(36,117,104.38)	
	Төвлөрүүлэх шилжүүлэг		36,117,104.38	(36,117,104.38)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,936,453,600.00	1,936,453,600.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,679,328,500.00	1,679,328,500.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,679,328,500.00	1,679,328,500.00		100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	257,125,100.00	257,125,100.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	257,125,100.00	257,125,100.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Тайлант оны	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,158,160.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,158,160.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,522,360.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,160,400.00	
210302	Түлш, халаалт	19,160,400.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	764,960.00	
210401	Бичиг хэрэг	764,960.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,597,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,597,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,635,800.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,632,800.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,621,400.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,011,400.00	
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,000.00	
	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91,158,160.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,158,160.00	
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,158,160.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовн туслах Э.Алтангэрэл, аудиторовн туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 23,065.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,299.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	147,817.4	163,164.8	15,347.4
Үндсэн хөрөнгө	3,213,871.2	3,265,081.6	51,210.4
Нийт хөрөнгө	3,361,688.7	3,428,246.4	66,557.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,361,688.7	3,428,246.4	66,557.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,361,688.7	3,428,246.4	66,557.7

Бараа материалын дансны үлдэгдэл 163,164.8 мянган төгрөг болж, 15,347.4 мянган төгрөгөөр өссөн. Бараа материалын данс худалдан авсан хөрөнгийн 77,634.4 мянган төгрөгөөр, Төв аймгийн Боловсрол соёл урлагийн газар болон Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас хандив тусламжаар авсан хөрөнгийн 2,129.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,265,081.6 мянган төгрөг болж 51,210.4 мянган төгрөгөөр өссөн. Үндсэн хөрөнгийн данс Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас хандиваар ирсэн 2,388.9 мянган төгрөгийн хөрөнгөөр, 212,043.2 мянган төгрөгийн их

засварын зардлыг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотойгоор, Төв аймгийн Боловсрол соёл урлагийн газраас хандиваар өгсөн 6,114.7 мянган төгрөгийн хөрөнгөөр, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас өгсөн 1,407.1 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс акталж устгасан 32,259.7 мянган төгрөгийн хөрөнгөөр, мөн тайлант хугацааны элэгдлийн зардлаар хасагджээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,244,515.7 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 1,188,281.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үйл ажиллагааны зардлын дүн өмнөх оноос 38,117.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс өссөн нь тайлант оны үр дүн 66,557.8 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,340,192.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,340,192.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 403,739.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,936,453.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,936,453.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,679,328.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 257,125.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,679,328.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 257,125.1 санхүүжилт авч нийт 1,936,453.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,900,336.5 мянган төгрөгийг зарцуулж, 36,117.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 91,158.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 91,155.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,244,515.7 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 1,188,281.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 2,681,079.5 мянган төгрөгийн 88 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,912,474.6 мянган төгрөгийн 54 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, хөрөнгө бэлтгээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, балансын дансадтай холбоотой 2 зөвлөмж, нийт 3 зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	3	72,871.6	3	72,871.6	-	-	100.0
Нийт дүн	3	72,871.6	3	72,871.6	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,928,901.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,309.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,480.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,917,112.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Төлбөрийн акт

1. Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 ажилтны цалингаас НДШ-ийн хувийг 12.5 хувиар тооцсоноос 104.5 мянган төгрөгийг, ХХОАТ чөлөөлөлгүй тооцсоноос 351.8 мянган төгрөгийг, нийт 456.3 мянган төгрөгийг илүү суутгасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 852.9 мянган төгрөгийг нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, УСНББОУС 12-т бараа материалд тавигдах шаардлага, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

Байгууллага нь нийт 1 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 10,480.0 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.8-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 214 ширхэг 114,555.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, санхүүгийн тайлангийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын жилийн эцсийн тооллогоор 4,637.7 мянган төгрөгийн түлш шатах тослох материалын үлдэгдэлд тооллого хийгдээгүй, тооллогын комисс дүгнэж хэлэлцээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", УСНББОУС-ын үндсэн шаардлага, санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журмыг мөрдлөг болгон ажиллах, хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулан үр дүнг хэлэлцэн баталгаажуулах

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Төв аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 2,681,079.5 мянган төгрөгийн 88 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,912,474.6 мянган төгрөгийн 54 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Цалинг буруу тооцоолж олгосон	1	456.3			1	456.3				
2	Хүнсний материал нөөцөлсөн	1	852.9			1	852.9				
3	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	10,480.0					1	10,480.0		
4	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй	1	-							1	-
5	Түлш шатах тослох материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, тооллогын комисс дүгнэж хэлэлцээгүй	1	4,637.7							1	4,637.7
Дүн		5	16,426.9	-	-	2	1,309.2	1	10,480.0	2	4,637.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	1,912,474.6							1	1,912,474.6
Дүн		1	1,912,474.6	-	-	-	-	-	-	1	1,912,474.6
Нийт дүн		6	1,928,901.5	-	-	2	1,309.2	1	10,480.0	3	1,917,112.3